



## ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №13

### *Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол*

2023 оны 10-р сарын 16 наас 11-р сарын 22 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

### *Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл*


2023 оны 10-р сарын 16 наас 11-р сарын 22 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N6, H3N8, H7N9, H5N1, H6N1, H10N8, H7N4, H5N8, H10N3 вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

Тухайн хугацаанд БНХАУ-н Сычуань мужийн Гуаньянь хотод сул хоруу H9N2 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн 1 тохиолдол бүртгэгдсэн.

### *Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:*

2023 оны 10-р сарын 16 наас 11-р сарын 22 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Аргентин, Австри, АНУ, Камбоджи, Бразил, Болгари, Канад, Колумби, Дани, Финланд, Фолклендын арлууд, Эквадор, Израйль, Энэтхэг, Португал, Мозамбик, Румын, Мексик, Герман, Унгар, Исланд, Япон, Итали, Польш, Норвеги, Их Британи, Испани, Өмнөд Африк, Швед, Серби, Тайвань, Уругвай, Вьетнам зэрэг 35 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 253 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 2 оос харна уу). Ихэвчлэн Цахлай, хараалай, хун, галуу, бүргэд, нугас зэрэг нүүдлийн усны, махчин 23 зүйлийн шувуу, хөхтөн амьтны 3 зүйлд өвчлөл бүртгэгдсэн. Нидерландын засгийн газар нь шувууны аж ахуйд 11-р сарын 11 нд шувууны томуугийн өвчлөл бүртгэгдсэн тул ферм, зэрлэг шувууны популяцид халдвар тархахаас сэргийлж, 65000 орчим тахиаг устгахаар шийдвэрлэсэн.

Төв болон Зүүн Азийн 14 улс оронд 2004 оноос хойш шувууны томуугийн өвчлөл 10181 тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс хүний өвчлөл 1826 (нас баралт 327), тэжээвэр шувууны аж ахуйд 6575, тандалтаар 234, нүүдлийн шувуудын дунд 1546 тохиолдол бүртгэгдсэн байна (зураг 1)



Зураг 1. Шувууны томуугийн өвчлөл 2004-2023 он

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5	Аргентин	Ягаан нал, хараалай, тахианы аж ахуй	3
H5N1	Австри	Бор галуу, гунгар хун	6
H5N1	АНУ	Тахианы аж ахуй, цацагт хяруул, зэрлэг нугас	48
H5N1	Болгари	Тахианы аж ахуй	2
H5N1	Бразил	Хараалай, далайн арслан, дэглий	19
H5N1	Камбоджи	Тахианы аж ахуй	2
H5, H5N1	Канад	Нугас, цацагт хяруул, тахианы аж ахуй,	26
H5N1	Колумб	Тахианы аж ахуй	3
H5N1	Дани	Тахианы аж ахуй	2
H5N1	Эквадор	Sula sula, цахлай	2
H...	Фолклендын арлууд	Fulmarus glacialisoides	1
H5	Финланд	2 зүйл үнэг, булга, шилүүс, галуу	18
H5N1	Франц	Мөнгөлөг цахлай	1
H5N1	Герман	Цахлай, нугас	
H5N1	Унгар	Тогоруу, нугас, шувууны аж ахуй	9
H5N1	Исланд	Хэрээ	2
H5N1	Энэтхэг	Хар хун	1
H5N1	Израйль	Хар өрөвтас, хар хун	2
H5	Итали	Нугас, цацагт хяруул	2
H5N1	Япон	Хэрээ, сар шувуу, харцага, гангар хун	4
H5N1	Мексик	Тахианы аж ахуй, ногоохон нугас	2
H7	Мозамбик	Тахианы аж ахуй	1
H5N1	Норвеги	Цагаан сүүлт бүргэд, мөнгөлөг цахлай	3
H5N1	Польш	Тахианы аж ахуй	1
H5N1	Португал	Цахлай	1
H5N1	Румын	Гунгар хун, шувууны аж ахуй	7
H5N1	Серби	Гунгар хун	3
H5N1	ОХУ	Тахианы аж ахуй	23
H7N6, H5	Өмнөд Африк	Тахианы аж ахуй, тэжээвэр тэмээн хяруул	42
H5N1	Испани	Цахлай	3
H5N1	Швед	Бор галуу, гангар хун	2
H5N1	Тайвань	Тахианы аж ахуй	2
H5N1	Их Британи	Тахианы аж ахуй, гургуул, цахлай, галуу	9
H5	Уругвай	Далайн хав, хараалай	4
H5N1	Вьетнам	Нугасны аж ахуй	3

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Зураг 2. 2023 оны 10-р сарын 16 наас 11-р сарын 22 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт

